

**“МОНГОЛ АЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 02 сарын 18 өдөр

№ 01.

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

“Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурал 2022 оны 2 сарын 18-ны өдрийн 11⁰⁰ цагт гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв.

Хуралд Компанийн ТУЗ-ийн дарга С.Дорждэрэм биечлэн оролцох боломжгүйгээ утсаар илэрхийлж, хурал даргалах гишүүнээр компанийн дүрмийн 8.18-дэхь заалтыг үндэслэн гишүүн М.Цолмонг томилж байгаагаа илэрхийлэв. Гишүүн М.Оюун, А.Болортуяа, хараат бус гишүүн Л.Базарсад, О.Лувсаншарав нар оролцов. Мөн Гишүүн Ж.Мөнхтөр, Л.Амарсанаа, Б.Саруул нар хэлэлцэх асуудлыг дэмжиж буйгаа утсаар илэрхийлсэн. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Батжаргал хурлын ирц хуулийн дагуу хүрч байгааг танилцуулав.

Ингээд хурлыг нээж хурал даргалагч, гишүүн М.Цолмон хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дэхь заалт, компанийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалтын дагуу ТУЗ ногдол ашиг олгох, эс олгох талаар шийдвэрээ гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ёстой.

Хурал даргалагч: Миний бие компанийн гүйцэтгэх захирлын хувьд ногдол ашиг олгох, эс олгох талаар мэдээлэл өгье.

Компани нь 1995 оноос эхлэн жил болгон ногдол ашгаа тогтмол олгож ирсэн. 2020, 2021 онуудад цар тахалтай холбоотой санхүүгийн байдал хүнд байгаа тул энэ жил ногдол ашиг хуваарилах боломжгүй байна.

Хурал даргалагч: Ингээд компанийн ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмаа 2021 оны үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар тайлан танилцуулна.

Хурал даргалагч: Та бүхэн тайлантай танилцлаа. Хэлэлцэж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Санал хүсэлт байвал хэлж болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Болортуяа: Дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Базарсад: Гүйцэтгэх захирлын саналыг дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн М.Оюун: Дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Лувсаншарав: Дэмжиж байна. Өнгөрсөн жил цар тахалтай холбоотой эдийн засгийн нөхцөл байдал хүнд байлаа.

Хурал даргалагч: Миний хувьд дэмжиж байгаа. Та бүхэнд өөр санал байвал хэлж болно. Байхгүй бол хурлаас доорхи тогтоолыг гаргахаар шийдвэрлэж байна. Та бүхэнд танилцуулья. Үүнд:

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, "Монгол алт" ХК-ийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалт, ТУЗ-ийн 2022 оны 2 сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.

Хурал даргалагч: Та бүхэн хурлаас гарах тогтоолын төсөлтэй танилцлаа. ТУЗ-ийн гишүүд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Энэ удаагийн ээлжит хурал өндөрлөж байна.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга Б.Батжаргал